



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ЗЭРЭГЛЭЛИЙГ ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА ТОГТООНО

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2025/ХШТ/04

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулсан.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь хохирогчтой маргалдан толгой, хөл, хэсэг рүү нь цохиж, тархинд битүү гэмтэл болон зүүн нүдний дээд, доод зовхинд цус хурсан, доод зовхинд шарх, зүүн нүдний салстад цус хуралт, хоолойд зулгаралт бүхий гэмтэл учруулсны улмаас хохирогчийн амь нас нь хохирсон гэмт хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Анхан шатны шүүхээс** шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт² заасан хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 11 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж, гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хохирол 115,500,000 төгрөгийг шүүгдэгчээс гаргуулан хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид олгохоор шийдвэрлэжээ.
- Давж заалдах шатны шүүхээс** анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.
- Шүүгдэгчийн өмгөөлөгч хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо** “...анхан шатны шүүх нь хэрэгт авагдсан баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд хянаж үзээгүй. Мөн гэрчүүдийн мэдүүлгээс үзэхэд шүүгдэгч нь хохирогчийг алах санаа, зорилго байгаагүй гэдгийг харж болно. Шүүгдэгч нь талийгаачийн эрүүл мэнд, амь насанд аюултай хохирол учруулах үйлдэл буюу толгой руу нь өшиглөж гэмтээсэн гэдгийг нотлоогүй тул шүүгдэгчийн буруутай үйлдлийн улмаас талийгаач нас барсан гэж үзэх үндэслэлгүй. Иймд анхан шатны шүүх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.7

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
https://shuukh.mn/single_case/3679?daterange=2025-01-01%20-%202025-12-15&id=3&court_cat=2&bb=1

² Эрүүгийн хууль(2015)-ийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “хүнийг алсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”



- дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1³ болон 1.3-т⁴ зааснаар шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хуулийг бурууг тайлбарлаж хэрэглэсэн байх тул анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж өгнө үү” гэжээ.
4. **Хяналтын шатны шүүхээс** хоёр шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтуудад тулгуурлан шүүгдэгчийг хүнийг алах буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжид хамаарч байгааг үндэслэлтэй тайлбарлаж, хуулийг зөв хэрэглэжээ. (37)⁵
 5. Нөгөөтээгүүр, анхан болон давж заалдах шатны шүүх **гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг шийдвэрлэхдээ хуулийг буруу тайлбарлан хэрэглэжээ.** (48).
 6. Шүүх шинжилгээний тухай хуулиар гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэцийн хор уршгийг үнэлэх, мөнгөн хэлбэрээр арилгуулахтай холбоотой зохицуулалтыг хуульчилсан. Энэ хүрээнд Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.5 дахь хэсэгт⁶ заасны дагуу хүнийг алах гэмт хэргийн улмаас нас барсан иргэний хамт амьдарч байсан гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, хууль ёсны төлөөлөгч **сэтгэцэд учирсан гэм хорыг шаардах эрх зүйн орчин бүрджээ.** (52).
 7. Сэтгэцийн хор уршгийн зэрэглэл тогтоох, мөнгөн хэлбэрээр арилгуулахтай холбоотой хууль тогтоомжийг судалж үзэхэд шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлд гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэцийн хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ хийх үндэслэл, журмыг хуульчилсан бол дүгнэлт гаргах журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар, нөхөн төлбөрийн хэмжээг Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.9 дахь хэсэгт⁷ заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын дээд шүүхээс баталсан жишиг аргачлалыг баримтлан шийдвэрлэхээр зохицуулсан байна. (53).
 8. Хүнийг алах гэмт хэргийн хувьд **шүүх шинжилгээний байгууллага гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргахаар хуульчилсан байна.** (55).
 9. Хоёр шатны шүүх дээрх хууль, журамд зааснаар шинжилгээ хийхгүйгээр амь хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан

³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.7 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг “шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй бол Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ”

⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг “хуулийн зүйл, хэсэг, заалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн бол Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ”

⁵ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

⁶ Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.5 дахь хэсэг “гэмт хэргийн улмаас нас барсан иргэний хамт амьдарч байсан гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, эсхүл насанд хүрээгүй гишүүний хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээд нь өөрийн сэтгэцэд учирсан гэм хорыг арилгуулахыг шаардах эрхтэй”

⁷ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсгийн 25.8.9-д “Улсын дээд шүүх нь хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийг тогтоохдоо харгалзан үзэх нөхөн төлбөрийн жишиг аргачлалыг Иргэний хууль, шүүхийн шийдвэр, практикт үндэслэн батлана”



хохирол 115,500,000 төгрөгийн нөхөн төлбөрийг гаргуулж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй болжээ. (56).

10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-т⁸ заасны дагуу шийтгэх тогтоол, магадлалд зохих өөрчлөлт оруулж, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан гэм хорын хохирлоо иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар жич нэхэмжлэх эрхтэйг дурдаж шийдвэрлэжээ. (57).

---oOo---

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.4 дахь хэсэг “хяналтын шатны шүүх нь хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах шийдвэр гаргана”